



## СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

### САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Сэлэнгэ аймгийн Сант сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

**Аудитын код: СЭА-2025/013/НА-СТА-ТТЗ**

Цахим хуудас: <a href="mailto:www.selenge@audit.gov.mn">www.selenge@audit.gov.mn</a> Сүхбаатар сум 2025 он	Дарга, тэргүүлэх аудитор: Ч.Энхтуяа Утас: 7036-3040 Цахим хаяг: <a href="mailto:enkhtuyach@audit.gov.mn">enkhtuyach@audit.gov.mn</a> Аудитын менежер: Б.Батмөнх Утас: 7036-3036 Цахим хаяг: <a href="mailto:batmunkhb@audit.gov.mn">batmunkhb@audit.gov.mn</a> Ахлах аудитор: Ц.Отгонбаяр Утас: 7036-3047 Цахим хаяг: <a href="mailto:Otgonbayarts@audit.gov.com">Otgonbayarts@audit.gov.com</a>
---	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## **Агуулга**

---

1. Аудитын дүгнэлт	3-5
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	6-11
3. Санхүүгийн тайлангийн тодруулга	12-20
3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа	12
3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин	13
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	13
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлт	14
3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв	17
4. Аудитын тайлан	21-25
4.1 Ерөнхий зүйл	21
4.2 Материаллаг байдал	21
4.3 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	22
4.4 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	23
4.5 Дараагийн аудитаар анхаарах асуудал	24
5. Аудитын илрүүлэлт	25-27
6. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл	28-29

## **Товчилсон үгийн жагсаалт**

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ААТҮГ	Аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар
АОУС	Аудитын олон улсын стандарт
ЗДНХ	Засаг Даргын нөөц хөрөнгө
ЗДТГ	Засаг даргын Тамгын газар
ИТХ	Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал
НДШ	Нийгмийн даатгалын шимтгэл
ОНЕО	Орон нутгийн ерөнхий орлого
ОНХС	Орон нутгийн хөгжлийн сан
ТБОНӨХБАҮХАТ	Төрийн болон орон нутгийн өмч хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай
ТТЗ	Төсвийн төвлөрүүлэн захирагч
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
ХХОАТ	Хүн амын орлогын албан татвар
ХХС	Хоршоо хөгжүүлэх сан
ШШГ	Шүүхийн шийдвэр гүйцэтгэх
ЭМД	Эрүүл мэндийн даатгал



## СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

II баг, Цагаан эрэг, Сүхбаатар сум,  
Сэлэнгэ аймаг, 43081  
Утас/Факс: (976)-7036-3040  
Цахим шуудан: Selenge@audit.gov.mn  
Цахим хуудас: www.audit.mn

САНТ СУМЫН ЗАСАГ ДАРГА  
С.ШИЖИРБААТАР ТАНАА

2025.03.25 № СА-2025/013/НА-СТА-773  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

### Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-т заасны дагуу Сэлэнгэ аймгийн Сант сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн байдал, санхүүгийн нэгтгэсэн үр дүн, нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан зөрчил нь материаллаг боловч өргөн тархаагүй гэж үзсэн бөгөөд санхүүгийн тайланд үзүүлэх нөлөөг эс тооцвол Сэлэнгэ аймгийн Сант сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Аудитаар дараах зөрчлүүд илэрсэн нь Төсвийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1, 16 дугаар зүйлийн 16.5.5, 41 дүгээр зүйлийн 41.2.1, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.4, 15.1.5, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1, 14.4.3, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 43 дугаар зүйлийн 43.3 дахь, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалаар баталсан “Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам”-ын 1.2, 190 дүгээр тушаалаар баталсан “Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар”-тай тус тус нийцээгүй бөгөөд санхүүгийн тайлангийн “Иж бүрэн байх”, “Нийцсэн бөгөөд зохистой” батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна. Үүнд:

- ЗДНХ-өөс сумын түүх соёлын дурсгалт газар, байгалийн цогцолбор газруудыг видео бичлэг, зураг, хар дүрс, фото зурагт буулган хадгалан үлдэх зорилгоор **4,879.6** мянган төгрөгийг “Монголын баялаг өв соёл” ХХК-тай гэрээ байгуулан шилжүүлж, гэрээт ажлыг хүлээн аваагүй,
- ЗДНХ-өөс сумын эрдэмтэн, докторуудад хүндэтгэл үзүүлж, 7 докторт **3,500.0** мянган төгрөгийн гарын бэлэг өгсөн,
- ЗДНХ-ийн батлагдсан төсвөөс **10.549.7** мянган төгрөгийг зориулалт бусаар зарцуулсан,
- Сумын ЗДТГ нь өөрийн орлогын төлөвлөгөөг **3,139.7** мянган төгрөгөөр тасалсан,
- Сумын ИТХ, ЗДТГ нь нийт **2,140.8** мянган төгрөгийг зориулалт бусаар буюу зардлын эдийн засгийн ангилал, арга хэмжээ хооронд гүйлгэн зарцуулж, гүйцэтгэлийг бодитоор тайлагнаагүй,
- Сумын ЗДТГ нь санхүүгийн программын **450.0** мянган төгрөгийн өр төлбөрийг өмнөх оны санхүүгийн тайланд тусгалгүйгээр тайлант оны батлагдсан төсвөөс барагдуулж, зардлаар тайлагнасан,
- Сумын ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэхээр баталсан 1 төсөл арга хэмжээний гүйцэтгэгчээс урьдчилгаа төлбөрийн баталгаа гаргуулалгүйгээр **14,000.0** мянган төгрөгийн урьдчилгаа санхүүжилт олгосон.

#### **Асуудлыг онцолсон хэсэг**

Тайлант онд төсвийн төвлөрүүлэн захирагчийн хэрэгжүүлэх 10 хөтөлбөрийн 30 арга хэмжээг санхүүжүүлэхээр 2,299,057.9 мянган төгрөгийн төсөв батлагдсанаас 1,493,128.3 мянган төгрөгийг урсгал зардалд, 597,098.3 мянган төгрөгийг хөрөнгийн зардалд, 208,831.0 мянган төгрөгийг ХХС-ийн зээлд зарцуулахаар төлөвлөсөн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл **1,649,375.3** мянган төгрөг буюу **71.7** хувьтай байгаа нь урсгал зардлыг 64,774.7 мянган төгрөгөөр, хөрөнгийн зардлыг 376,076.5 мянган төгрөгөөр, эргэж төлөгдөх зээлийг 208,831.0 мянган төгрөгөөр тус тус хэмнэснээс шалтгаалсан байна.

#### **Аудитын гол асуудал**

Аймгийн ЗДТГ-ын СТСХ-ээс малын хөлийн татварын 98,717.8 мянган төгрөгийг сумын суурь орлогод нэмж баталсан, үл хөдлөх хөрөнгийн албан татварын сүүлийн 3 жилийн дундаж гүйцэтгэл 2,000.0 мянган төгрөг байхад аймгийн төсвийн орлогын мэргэжилтэн орон андуурч 20,000.0 төгрөгөөр тооцсон зэргээс шалтгаалан аймгаас олгох санхүүгийн дэмжлэгийг багаар баталснаас зардлаа нөхөхийн тулд орон нутгийн төсвийн орлогын төлөвлөгөөг хэт өндрөөр төлөвлөж, төлөвлөгөөг 110,024.1 мянган төгрөгөөр буюу 15.1 хувиар тасалсан байна.

#### **Бусад асуудлын хэсэг**

Сант сумын Засаг дарга нь тайлант онд 5 зорилт, 105 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, 88.5 хувийн хэрэгжилттэй тайлагнасан байна.

Санхүүгийн тайланд толилуулж, тодруулснаас бусад аудиторын шийдлээр онцлох асуудал байхгүй болно.

### **Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

### **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ч.ЭНХТУЯА

## 2. Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэл

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан

(мянган төгрөгөөр)

Код:	Тайлангийн үзүүлэлт	2023оны 12-р сарын 31	2024 оны 12-р сарын 31
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>445,500.80</b>	<b>577,159.40</b>
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	209,651.70	383,607.60
33	АВЛАГА	215,473.80	174,372.10
35	БАРАА МАТЕРИАЛ	20,375.20	19,179.70
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>2,403,318.50</b>	<b>5,486,141.80</b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	<b>2,403,318.50</b>	<b>5,486,141.80</b>
39200	Биет хөрөнгө	1,813,636.90	4,895,161.30
39300	Биет бус хөрөнгө	589,681.60	590,980.50
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b>2,848,819.20</b>	<b>6,063,301.20</b>
<b>4</b>	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>	<b>53.1</b>	<b>42.5</b>
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	53.1	42.5
41300	Өглөг	53.1	42.5
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b>2,848,766.20</b>	<b>6,063,258.70</b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	<b>2,848,766.20</b>	<b>6,063,258.70</b>
51100	Засгийн газрын оруулсан капитал	627,122.10	627,122.10
<b>51200</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	<b>1,869,077.30</b>	<b>5,083,569.80</b>
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	352,566.80	352,566.80
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b>2,848,819.20</b>	<b>6,063,301.20</b>

### 2.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан

(мянган төгрөгөөр)

Код:	Тайлангийн үзүүлэлт	2023оны 12-р сарын 31	2024 оны 12-р сарын 31
<b>I</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>1,797,723.89</b>	<b>5,315,616.70</b>
<b>11</b>	<b>ТАТВАРЫН ОРЛОГО</b>	<b>419,043.64</b>	<b>545,647.70</b>
<b>110</b>	<b>Орлогын албан татвар</b>	<b>163,806.60</b>	<b>358,636.00</b>
1100	Хувь хүний орлогын албан татвар	188,957.20	387,346.70
1101	Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт	-25,150.60	-28,710.70
113	Хөрөнгийн албан татвар	93,462.97	78,013.60
118	Бусад татвар, төлбөр, хураамж	161,774.07	108,998.10
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>517,835.26</b>	<b>3,572,161.00</b>
120	Нийтлэг татварын бус орлого	517,835.26	3,572,161.00
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>860,844.99</b>	<b>1,197,807.90</b>
<b>II</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>1,228,122.50</b>	<b>1,699,243.70</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>1,228,122.50</b>	<b>1,699,243.70</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>1,226,057.50</b>	<b>1,635,703.60</b>
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	473,075.68	741,520.80
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	58,539.94	88,453.30
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	43,997.46	395,070.00
2104	Хангамж, бараа материалын зардал	40,408.31	56,404.20
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	8,902.60	23,754.60

2107	Томилолт, зочны зардал	6,274.00	8,041.90
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	349,418.37	7,150.30
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	245,441.14	315,308.50
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>2,065.00</b>	<b>63,540.20</b>
<b>III</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)</b>	<b>569,601.39</b>	<b>3,616,373.00</b>
<b>V</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>330,834.80</b>	<b>401,880.50</b>
<b>VI</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)</b>	<b>238,766.59</b>	<b>3,214,492.50</b>

## 2.4 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан

(мянган төгрөгөөр)

Код:	Тайлангийн үзүүлэлт	2023оны 12-р сарын 31	2024 оны 12-р сарын 31
<b>I</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>1,371,941.46</b>	<b>1,887,907.60</b>
<b>11</b>	<b>ТАТВАРЫН ОРЛОГО</b>	<b>434,845.84</b>	<b>545,647.70</b>
<b>110</b>	<b>Орлогын албан татвар</b>	<b>163,806.61</b>	<b>358,636.00</b>
1100	Хувь хүний орлогын албан татвар	188,957.24	387,346.70
1101	Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт	-25,150.63	-28,710.70
<b>113</b>	<b>Хөрөнгийн албан татвар</b>	<b>109,265.16</b>	<b>78,013.60</b>
<b>118</b>	<b>Бусад татвар, төлбөр, хураамж</b>	<b>161,774.07</b>	<b>108,998.10</b>
1180	Бусад нийтлэг төлбөр, хураамж	5,019.50	7,331.40
1181	Газрын төлбөр	138,176.91	84,122.70
1182	Байгалийн нөөц ашигласны төлбөр	18,577.66	17,544.00
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>92,052.83</b>	<b>120,355.40</b>
120	Нийтлэг татварын бус орлого	92,052.83	120,355.40
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>845,042.79</b>	<b>1,221,904.40</b>
<b>II</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>1,068,901.02</b>	<b>1,492,929.90</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>1,068,901.02</b>	<b>1,492,929.90</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>1,066,836.02</b>	<b>1,429,389.70</b>
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	476,671.00	737,580.50
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	59,052.94	88,453.30
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	43,964.36	395,103.10
2104	Хангамж, бараа материалын зардал	40,291.31	46,664.40
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	22,196.90	29,365.50
2107	Томилолт, зочны зардал	6,274.00	8,041.90
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	350,738.36	7,150.30
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	67,647.15	117,030.80
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>2,065.00</b>	<b>63,540.20</b>
<b>III</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)</b>	<b>303,040.44</b>	<b>394,977.70</b>
<b>V</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)</b>	<b>311,864.40</b>	<b>221,021.80</b>
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	311,864.40	221,021.80
2200	Дотоод эх үүсвэрээр	311,864.40	221,021.80
<b>VI</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)</b>	<b>-311,864.40</b>	<b>-221,021.80</b>

VII	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН	-156,660.00	0
23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	156,660.00	0
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	<b>-165,483.96</b>	<b>173,955.90</b>
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	375,135.67	209,651.70
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	209,651.71	383,607.60

### 2.3 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

(мянган төгрөгөөр)

Код:	Тайлангийн үзүүлэлт	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн	Цөөнхийн хувь оролцоо	Нийт цэвэр хөрөнгө/өмч
1	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	2,609,773.80	0	2,609,773.80
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	225.8	0	225.8
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	2,609,999.60	0	2,609,999.60
9	Тайлант үеийн үр дүн	238,766.60	0	238,766.60
10	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	2,848,766.20	0	2,848,766.20
11	2024 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	2,848,766.20	0	2,848,766.20
12	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0	0	0
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	2,848,766.20	0	2,848,766.20
19	Тайлант үеийн үр дүн	3,214,492.50	0	3,214,492.50
20	2024 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	6,063,258.70	0	6,063,258.70

### 2.5 Аудит хийсэн нэгтгэсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

(мянган төгрөгөөр)

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	2,299,057.60	1,649,375.40	649,682.20	71.74
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,493,128.30	1,428,353.60	64,774.70	95.66
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,435,674.50	1,371,813.40	63,861.10	95.55
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	759,600.50	735,166.70	24,433.80	96.78
210101	Үндсэн цалин	421,778.70	417,296.50	4,482.20	98.94
210102	Нэмэгдэл	333,543.90	304,690.10	28,853.80	91.35
210104	Урамшуулал	4,277.90	13,180.10	-8,902.20	308.10
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	89,814.40	88,282.90	1,531.50	98.29
210201	Тэтгэврийн даатгал	62,022.40	61,012.50	1,009.90	98.37

210202	Тэтгэмжийн даатгал	6,802.60	6,916.80	-114.20	101.68
210203	ҮОМШӨ-ний даатгал	12,907.20	13,050.30	-143.10	101.11
210204	Ажилгүйдлийн даатгал	2,550.50	3,180.40	-629.90	124.70
210205	Эрүүл мэндийн даатгал	5,531.70	4,122.90	1,408.80	74.53
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>397,442.10</b>	<b>392,849.30</b>	<b>4,592.80</b>	<b>98.84</b>
210301	Гэрэл, цахилгаан	50,344.60	45,752.40	4,592.20	90.88
210302	Түлш, халаалт	342,688.00	342,687.40	0.60	100.00
210303	Цэвэр, бохир ус	4,409.50	4,409.50	0.00	100.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>64,478.50</b>	<b>45,508.40</b>	<b>18,970.10</b>	<b>70.58</b>
210401	Бичиг хэрэг	7,491.30	6,106.10	1,385.20	81.51
210402	Тээвэр, шатахуун	47,971.70	31,906.80	16,064.90	66.51
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,727.00	3,525.10	201.90	94.58
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	500.00	500.00	0.00	100.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	4,788.50	3,470.30	1,318.20	72.47
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>30,583.60</b>	<b>28,225.50</b>	<b>2,358.10</b>	<b>92.29</b>
210601	Багаж, техник, хэрэгсэл	5,021.00	5,021.00	0.00	100.00
210604	Урсгал засвар	25,562.60	23,204.50	2,358.10	90.78
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>10,630.00</b>	<b>8,041.90</b>	<b>2,588.10</b>	<b>75.65</b>
210702	Дотоод албан томилолт	10,630.00	8,041.90	2,588.10	75.65
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>9,986.10</b>	<b>7,150.30</b>	<b>2,835.80</b>	<b>71.60</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	8,047.40	5,648.80	2,398.60	70.19
210803	Даатгалын үйлчилгээ	323.00	322.90	0.10	99.97
210804	Тээврийн хэрэгслийн татвар	474.30	387.10	87.20	81.62
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	176.00	176.00	0.00	100.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	350.00	0	350.00	-
210807	Газрын төлбөр	615.40	615.40	0.00	100.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>73,139.30</b>	<b>66,588.30</b>	<b>6,551.00</b>	<b>91.04</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	71,663.00	65,232.10	6,430.90	91.03
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,476.30	1,356.30	120.00	91.87
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>57,453.80</b>	<b>56,540.20</b>	<b>913.60</b>	<b>98.41</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>57,453.80</b>	<b>56,540.20</b>	<b>913.60</b>	<b>98.41</b>
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	18,063.60	18,063.60	0.00	100.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	37,226.60	37,226.60	0.00	100.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	2,163.60	1,250.00	913.60	57.77
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>597,098.30</b>	<b>221,021.80</b>	<b>376,076.50</b>	<b>37.02</b>
220001	Барилга байгууламж	324,183.40	78,613.70	245,569.70	24.25
222001	Тоног төхөөрөмж	231,562.60	113,042.30	118,520.30	48.82
223001	Бусад хөрөнгө	41,352.30	29,365.80	11,986.50	71.01
<b>23</b>	<b>ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ</b>	<b>208,831.00</b>	<b>0</b>	<b>208,831.00</b>	<b>-</b>
230001	Эргэж төлөгдөх зээл	208,831.00	0	208,831.00	-
<b>III</b>	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>2,299,057.60</b>	<b>1,889,897.10</b>	<b>409,160.50</b>	<b>82.20</b>
<b>32</b>	<b>ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	<b>1,956,799.40</b>	<b>1,843,164.40</b>	<b>113,635.00</b>	<b>94.19</b>
320001	Орон нутгийн төсвөөс	1,619,923.70	1,518,079.30	101,844.40	93.71
320002	Орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжих	336,875.70	325,085.10	11,790.60	96.50

<b>35</b>	<b>ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС</b>	<b>342,258.20</b>	<b>46,732.70</b>	<b>295,525.50</b>	<b>13.65</b>
350001	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	200,707.50	46,732.70	153,974.80	23.28
350003	Урьд оны үлдэгдлээс санхүүжих	141,550.70	0	141,550.70	-
<b>61</b>	<b>БАЙГУУЛЛАГЫН ТОО</b>	<b>2</b>	<b>2</b>	<b>0.00</b>	<b>100.00</b>
610001	Төсвийн байгууллага	2	2	0.00	100.00
<b>62</b>	<b>АЖИЛЛАГСАДЫН ТОО</b>	<b>25</b>	<b>22</b>	<b>3.00</b>	<b>88.00</b>
620001	Удирдах ажилтан	7	5	2.00	71.43
620002	Гүйцэтгэх ажилтан	13	12	1.00	92.31
620003	Үйлчлэх ажилтан	5	5	0.00	100.00
<b>65</b>	<b>ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ</b>	<b>25</b>	<b>22</b>	<b>3.00</b>	<b>88.00</b>
650001	Төрийн захиргааны албан хаагч (ТЗ)	11	9	2.00	81.82
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	9	9	0.00	100.00
650011	Улс төрийн албан хаагч (УТ)	5	4	1.00	80.00

## 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

(мянган төгрөгөөр)

Код	Үзүүлэлт	ТЗ цэвэр дүн
<b>II</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>44,155.80</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>44,155.80</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>33,479.90</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>2,413.80</b>
210101	Үндсэн цалин	1,846.80
210104	Урамшуулал	567.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>170.30</b>
210201	Тэтгэврийн даатгал	126.70
210202	Тэтгэмжийн даатгал	9.80
210203	ҮОМШӨ-ний даатгал	16.40
210204	Ажилгүйдлийн даатгал	6.50
210205	Эрүүл мэндийн даатгал	10.90
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>2,253.80</b>
210301	Гэрэл, цахилгаан	2,253.80
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>1,155.90</b>
210402	Тээвэр, шатахуун	1,155.90
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>1,140.00</b>
210601	Багаж, техник, хэрэгсэл	1,140.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>26,345.90</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	26,345.90
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>10,675.90</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>7,000.00</b>
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	7,000.00
<b>2133</b>	<b>Олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	<b>3,675.90</b>

213405	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	3,675.90
<b>I</b>	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>44,155.80</b>
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>44,155.80</b>
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	9,365.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	34,790.80

### 3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

---

#### 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Сэлэнгэ аймгийн Сант сумын төсвийн төвлөрүүлэн захирагч /цаашид Сант сумын ТТЗ гэх/-ийн 2024 оны үйл ажиллагааны зорилгыг *“Иргэдийн оролцоотой цахим хөгжлийн жил”* гэж тодорхойлсон байна.

Дээрх дэвшүүлсэн зорилт арга хэмжээний хүрээнд дор дурдсан үйл ажиллагааны стратегийн зорилтыг хэрэгжүүлэхээр тодорхойлсон байна. Үүнд:

- ✓ Төрийн ажил үйлчилгээний ил тод нээлттэй байдлыг хангах,
- ✓ Төрийн албан хаагчдын сахилга хариуцлагыг дээшлүүлэх,
- ✓ Төсөвт байгууллагуудын үйл ажиллагааг уялдуулж, иргэдийн оролцоог хангаж хамтран ажиллах,
- ✓ Төрийн бодлого, хууль тогтоомж, ИТХ-ын шийдвэрийг хэрэгжүүлэх, сурталчлах, биелэлтийг нь хангах ажлыг нутаг дэвсгэрийнхээ хэмжээнд зохион байгуулах үндсэн дээр хүн амын хүнсний аюулгүй байдлыг хангах, мал сүргийг өсгөн үржүүлэх, малын удмын сан, эрүүл мэндийг хамгаалах, мал эмнэлэг, үржлийн ажлыг зохион байгуулах, байгалийн гэнэтийн аюул, мал, амьтан, ургамлын халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээг бүрэн эрхийнхээ хүрээнд авч хэрэгжүүлэх,
- ✓ Харьяалах нутаг дэвсгэрийнхээ эдийн засаг, нийгмийн хөгжлийн стратегийн төлөвлөлт, хөтөлбөр, төсөл зохиох, зохицуулах, хяналт шинжилгээ хийх, үнэлж дүгнэх, бодлогын удирдамжаар хангах,
- ✓ Харьяалах нутаг дэвсгэрийнхээ болон засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж хоорондын, түүнчлэн бүс нутгийн чанартай үйлдвэрлэл, үйлчилгээ, нийгэм-соёлын зориулалттай барилга байгууламж барьж байгуулахад орон нутгийн болон хувийн хөрөнгө оруулалт хийх ажлыг дэмжиж, зохион байгуулах,
- ✓ Төрийн ажилтныг бэлтгэх, давтан сургах, мэргэшүүлэх, тэдний ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах ажлыг хууль тогтоомжийн хүрээнд зохион байгуулах,
- ✓ Нутаг дэвсгэрийн эдийн засаг, нийгмийн хөгжлийн хэтийн зорилт болон жилийн эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлийн төсөл, гүйцэтгэлийн тайлан, орон нутгийн төсвийн болон түүнд нэмэлт, өөрчлөлт оруулах төсөл, төсвийн гүйцэтгэлийн тайланг батлуулахаар тухайн ИТХ-д оруулах, батлагдсан хөтөлбөр, төсөв, төслийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах,
- ✓ Нутаг дэвсгэрийнхээ татварын орлогыг хууль тогтоомж, ИТХ-ын шийдвэрийн дагуу төвлөрүүлэх, шилжүүлэх ажлыг зохион байгуулах,
- ✓ Төрийн болон тухайн орон нутгийн өмчийн талаарх төрийн бодлого, хууль тогтоомж, ИТХ-ын шийдвэрийн биелэлтийг хангах ажлыг зохион байгуулах гэх мэт.

### **3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин**

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль, тогтоомж, бодлого журамд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- *Монгол Улсын 2024 оны Төсвийн тухай хуулиар төсөв, санхүүжилттэй холбоотой,*
- *Нийгмийн даатгалын ерөнхий хуульд 2024 оны 06 дугаар сарын 05-нд нэмэлт өөрчлөлт орсон,*
- *Хөдөлмөрийн тухай хуульд 2024 оны 01 дүгээр сарын 12, 06 дугаар сарын 05-нд нэмэлт өөрчлөлт орсон,*
- *Төрийн хэмнэлтийн тухай хуульд 2024 оны 01 дүгээр сарын 17, 12 дугаар сарын 12-нд нэмэлт өөрчлөлт орсон,*
- *Төрийн албаны тухай хуульд 2024 оны 05 дугаар сарын 16, 06 дугаар сарын 05-нд нэмэлт өөрчлөлт орсон,*
- *Засгийн газрын 2024 оны 02 дугаар сарын 28-ны өдрийн 83 дугаар тогтоолоор төрийн захиргааны албан хаагчид мөнгөн урамшуулал олгох журмыг баталсан,*
- *Засгийн газрын 2024 оны 03 дугаар сарын 27-ны өдрийн 128 дугаар тогтоолоор төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоосон,*
- *Сангийн сайдын 2024 оны 04 дүгээр сарын 01-ний өдрийн А/52 дугаар тушаалаар дотоод албан томилолтын зардлын хэмжээг шинэчлэн баталсан гэх мэт.*

### **3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал**

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Сант сумын ТТЗ-ийн 2024 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Сэлэнгэ аймгийн Засаг даргын 2021 оны 02 дугаар сарын 23-ны өдрийн А/58 дугаар захирамжаар баталсан Сэлэнгэ аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн багцад харьяалагдах төсөвт байгууллагуудын хэмжээнд мөрдөгдөх нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг мөрдөн ажиллаж байна.

Тус байгууллагын үйл ажиллагаанд мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

### **3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд**

Сант сумын ТТЗ-ийн 2024 оны санхүүгийн санхүүгийн нэгтгэсэн тайланг Сангийн сайдын 2015 оны 341 дүгээр тушаалаар баталсан “Төсвийн ерөнхийлөн

захирагчийн болон Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайлан, тодруулга бэлтгэх журам”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 3,214,482.0 мянган төгрөгөөр буюу 1.1 дахин өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	209,651.70	383,607.60	173,955.90
Авлага	215,473.80	174,372.10	(41,101.70)
Бараа материал	20,375.20	19,179.70	(1,195.50)
Үндсэн хөрөнгө	2,403,318.50	5,486,141.80	3,082,823.30
<b>Нийт хөрөнгө</b>	<b>2,848,819.20</b>	<b>6,063,301.20</b>	<b>3,214,482.00</b>
Өр төлбөр	53.00	42.50	(10.50)
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	2,848,766.20	6,063,258.70	3,214,492.50
<b>Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн</b>	<b>2,848,819.20</b>	<b>6,063,301.20</b>	<b>3,214,482.00</b>

Дээрх хүснэгтээс харахад, нийт хөрөнгийн үлдэгдэл 6,063,301.2 мянган төгрөг болж, 3,214,482.0 мянган төгрөгөөр өссөн нь аймаг, сумын ОНХО болон ОНХС-ийн эх үүсвэрээр бэлтгэсэн хөрөнгө нэмэгдсэнтэй холбоотой байна.

### 3.4.1 Мөнгөн хөрөнгө

Мөнгөн хөрөнгийн дансны эхний үлдэгдэл 209,651.7 мянган төгрөг байсан бол эцсийн үлдэгдэл 383,607.6 мянган төгрөг болж, 173,955.9 мянган төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 2. Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Касст байгаа бэлэн мөнгө			
Банканд байгаа бэлэн мөнгө	209,651.70	383,607.60	173,955.90
<b>Дүн</b>	<b>209,651.70</b>	<b>383,607.60</b>	<b>173,955.90</b>

Эх сурвалж: Санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан

Мөнгөн хөрөнгийн үлдэгдэлд тайлагнагдсан ОНХО-ын дансанд 17,337.3 мянган төгрөг, ОНХС-ийн дансанд 306,977.3 мянган төгрөг, ХХС-ийн дансанд 52,292.9 мянган төгрөг зэрэг нийт 383,607.6 мянган төгрөг төрийн сангийн харилцах дансанд байршиж байна.

### 3.4.2 Авлага

Авлага дансны эхний үлдэгдэл 215,473.8 мянган төгрөг байсан бол эцсийн үлдэгдэл 174,372.1 мянган төгрөг болж, 41,101.7 мянган төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт 3. Авлагын үлдэгдэл

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Байгууллагаас авах авлага	2,590.70	1,270.70	(1,320.00)
Ажиллагчидтай холбоотой авлага	4,166.10	0.00	(4,166.10)
Хувь хүмүүсээс авах авлага	6,085.60	6,085.60	-
Хувь хүмүүст олгосон зээл	187,595.50	156,132.95	(31,462.55)
Зээлийн хүүгийн авлага	15,035.90	10,882.85	(4,153.05)
<b>Дүн</b>	<b>215,473.80</b>	<b>174,372.10</b>	<b>(41,101.70)</b>

Эх сурвалж: Санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан

Авлага дансны эцсийн үлдэгдэлд дараах авлагууд тайлагнагдсан байна. Үүнд:

- ЗДТГ-ын байгууллагаас авах авлагын дансанд 2022 онд үүссэн “Гавшгай ус” ОНӨААТҮГ-аас авах усны төлбөрийн 1,270.7 мянган төгрөгийн,
- ОНӨО-ын дансанд бүртгэлтэй 2010-2011 онд 5 иргэнд олгосон итгэлийн зээлийн төлөгдөөгүй үлдэгдэл 6,085.6 мянган төгрөгийн /авлагыг барагдуулахаар шүүхийн шийдвэр гүйцэтгэлд шилжүүлэн эвлэрүүлэн зуучлалын журмаар маргаанаа шийдвэрлэхээр тогтсон байна/,
- Хоршоо хөгжүүлэх сангаас олгосон эргэн төлөгдөх зээлийн 156,132.9 мянган төгрөг, зээлийн хүүгийн 10,882.8 мянган төгрөг зэрэг

### 3.4.3 Бараа материал

Бараа материалын дансны эхний үлдэгдэл 20,375.2 мянган төгрөг байсан бол эцсийн үлдэгдэл 19,179.7 мянган төгрөг болж, 1,195.5 мянган төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт 5. Бараа материалын үлдэгдэл

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Бичиг хэргийн материал	210.00	170.00	(40.00)
Аж ахуйн материал	17,782.90	19,009.70	1,226.80
Бусад хангамжийн материал	2,382.30	-	(2,382.30)
<b>Дүн</b>	<b>20,375.20</b>	<b>19,179.70</b>	<b>(1,195.50)</b>

Эх сурвалж: Санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан

Материалын дансны үлдэгдэл 1,195.5 мянган төгрөгөөр буурсан нь тайлант онд төсвийн хөрөнгөөр 84,508.2 мянган төгрөгийн бараа материал худалдан авсан, усалгаатай тариалан төслөөс 4,853.3 мянган төгрөгийн бараа материал үнэ төлбөргүйгээр хүлээн авсан болон 90,556.9 мянган төгрөгийн бараа материалыг зарцуулсантай холбоотой байна.

### 3.4.4 Үндсэн хөрөнгө

Үндсэн хөрөнгийн дансны үлдэгдэл 2,403,318.5 мянган төгрөг байсан бол эцсийн үлдэгдэл 5,486,141.8 мянган төгрөг болж, 3,082,823.3 мянган төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 6. Үндсэн хөрөнгийн үлдэгдэл

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Барилга, байгууламж, орон сууц	580,140.40	3,389,573.90	2,809,433.50
Авто-тээврийн хэрэгсэл	105,713.00	194,166.40	88,453.40
Машин тоног төхөөрөмж(компьютер)	63,001.80	56,985.10	(6,016.70)
Тавилга, аж ахуйн эд хогшил	7,715.40	61,068.40	53,353.00
Бусад үндсэн хөрөнгө	1,048,166.30	1,148,201.30	100,035.00
Дуусаагүй барилга байгууламж	8,900.00	45,166.20	36,266.20
Программ хангамж	1,720.00	3,018.90	1,298.90
Бусад биет бус хөрөнгө	587,961.60	587,961.60	-
<b>Дүн</b>	<b>2,403,318.50</b>	<b>5,486,141.80</b>	<b>3,082,823.30</b>

Эх сурвалж: Санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан

Үндсэн хөрөнгийн дансны үлдэгдэл 3,082,823.3 мянган төгрөгөөр өссөн нь төсвийн хөрөнгөөр 19,119.9 мянган төгрөгийн хөрөнгө худалдан авсан, улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2,907,617.8 мянган төгрөгийн үерийн далан, ОБЕГ-аас 106,900.0 мянган төгрөгийн суудлын автомашин, аймаг, сумын ОНХС-ийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн 287,364.8 мянган төгрөгийн цэвэр усны шугамын засвар, хашаа, худаг зэргийг үнэ төлбөргүйгээр хүлээн авч, үндсэн хөрөнгийн данс хооронд 161,545.5 мянган төгрөгийн хөрөнгө шилжүүлж, тайлант онд 237,985.8 мянган төгрөгийн элэгдлийн зардал байгуулсантай холбоотой байна.

### 3.4.5 Өр төлбөр

Нийт өр төлбөрийн дансны эхний үлдэгдэл 53.1 мянган төгрөг байсан бол эцсийн үлдэгдэл 42.5 мянган төгрөг болж 10.6 мянган төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт 7. Нийт өр төлбөрийн үлдэгдэл

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Бараа, үйлчилгээний зардлын өглөг	33.10		(33.10)
Хувь хүмүүст төлөх өглөг	20.00	42.50	22.50
<b>Дүн</b>	<b>53.10</b>	<b>42.50</b>	<b>(10.60)</b>

Эх сурвалж: Санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан

Өр төлбөрийн дансны үлдэгдэлд ХХС-ийн хувь хүнд өгөх өглөгийн 42.5 мянган төгрөгийн өр төлбөр тус тус тайлагнагдсан байна.

### 3.4.6 Засгийн газрын хувь оролцоо

Засгийн газрын хувь оролцоо дансны эхний үлдэгдэл 2,848,766.2 мянган төгрөг байсан бол эцсийн үлдэгдэл 6,063,258.7 мянган төгрөг болж, 3,214,492.5 мянган төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 8. Засгийн газрын хувь оролцоо

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	627,122.10	627,122.10	-

Хуримтлагдсан үр дүн	1,869,077.30	5,083,569.80	3,214,492.50
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	352,566.80	352,566.80	-
<b>Дүн</b>	<b>2,848,766.20</b>	<b>6,063,258.70</b>	<b>3,214,492.50</b>

Эх сурвалж: Санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан

Засгийн газрын хувь оролцоо дансны үлдэгдэл өссөн нь хуримтлагдсан үр дүнтэй холбоотой байна.

### 3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### Орон нутгийн төсвийн орлого бүрдүүлэлт:

Сумын ИТХ-ын 2024 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн “Сант сумын 2024 оны тодотгосон төсөв батлах тухай” 108 дугаар тогтоолоор 729,294.7 мянган төгрөгийн татварын болон татварын бус орлогыг орон нутгийн төсөвт төвлөрүүлэхээр баталснаас гүйцэтгэлээр 619,270.6 мянган төгрөгийг төвлөрүүлж, төлөвлөгөөг 15.1 хувиар тасалсан байна.

Хүснэгт 9. Төвлөрүүлэх орлого

/мянган төгрөг/

№	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
1	Сумын төсвийн татварын болон татварын бус орлого	729,294.70	619,270.60	110,024.10	84.91
2	Сумын төсвийн татварын орлого	659,215.50	545,647.90	113,567.60	82.77
3	Цалин хөлс түүнтэй адилтгах орлогын суутган	219,857.50	266,046.20	-46,188.70	121.01
4	Үйл ажиллагааны орлого	75,700.00	99,982.00	-24,282.00	132.08
5	Хөрөнгийн орлого	12,382.70	16,033.90	-3,651.20	129.49
6	Хөрөнгө борлуулсны орлого	6,810.50	5,284.60	1,525.90	77.59
7	Бууны албан татвар	1,500.00	810.00	690.00	54.00
8	Малд ногдуулах албан татвар	232,746.80	76,720.30	156,026.50	32.96
9	ҮХХАТатвар	20,000.00	483.30	19,516.70	2.42
10	Улсын тэмдэгийн хураамж	3,500.00	5,847.40	-2,347.40	167.07
11	Түгээмэл тархацтай АМ ашигласны төлбөр	500.00	480.00	20.00	96.00
12	Хог хаягдал үйлчилгээ	500.00	1,004.00	-504.00	200.80
13	Газрын төлбөр	15,000.00	17,393.40	-2,393.40	115.96
14	дуудлага худалдааны орлого	63,768.30	66,729.40	-2,961.10	104.64
15	ХХОАТ-ын буцаалт	(28,710.70)	(28,710.60)	-0.10	100.00
16	Ойн нөөц ашигласны төлбөр	23,002.40	13,619.10	9,383.30	59.21

17	Агнуурын нөөц ашигласны төлбөр	2,658.00	1,701.00	957.00	64.00
18	Байгалийн ургамал ашигласны төлбөр	10,000.00	2,223.90	7,776.10	22.24
<b>19</b>	<b>Сумын төсвийн татварын бус орлого</b>	<b>70,079.20</b>	<b>73,622.70</b>	<b>-3,543.50</b>	<b>105.06</b>
20	Бусад орлого	2,790.00	4,390.00	-1,600.00	157.35
21	Торгуулийн орлого	60,000.00	61,011.60	-1,011.60	101.69
22	Түрээсийн орлого	7,289.20	8,221.10	-931.90	112.78

Төсвийн орлогод нөлөөлөхүйц хэмжээний төлөвлөгөөнөөс давсан болон тасарсан орлогуудын шалтгааныг тодруулбал:

### **Давсан орлого**

- Цалин, хөлс, шагнал, урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрхлэлтийн орлого 46,188.7 мянган төгрөгөөр давж биелсэн нь Засгийн газрын 2024 оны 241 дүгээр тогтоолоор төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоож цалин хөлс нэмэгдсэнтэй холбоотой,
- Үйл ажиллагааны орлого 24,282.0 мянган төгрөгөөр давж биелсэн нь ноос, ноолуурын урамшуулалд хамрагдсан иргэдийн тоо өссөнтэй холбоотой байна.

### **Тасарсан орлого:**

- Малын тоо толгойн албан татвар 156,026.5 мянган төгрөгөөр тасарсан нь аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчаас малын хөлийн татварын 98,717.8 мянган төгрөгийг суурь орлогод тооцож баталсан, тайлант онд татварын байцаагчгүй байсан зэргээс,
- Үл хөдлөх эд хөрөнгийн албан татвар 19,516.7 мянган төгрөгөөр тасарсан нь аймгийн төрийн сангийн орлогын мэргэжилтэн орон андуурч орлогыг өндөр төлөвлөсөнтэй холбоотой,
- Ойн нөөц ашигласны төлбөр 9,383.3 мянган төгрөгөөр, байгалийн ургамал ашигласны төлбөр 7,776.1 мянган төгрөгөөр тасарсан нь орлогыг хэт өндрөөр төлөвлөснөөс тус тус шалтгаалсан байна.

### **3.5.1 Төсвийн төлөвлөлт**

Тус төвлөрүүлэн захирагчийн 2024 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг аймгаас авах санхүүгийн дэмжлэгийг 1,665,216.9 мянган төгрөгөөр, татварын болон татварын бус орлогоос 415,822.4 мянган төгрөгөөр, өөрийн үйл ажиллагааны орлогоос 5000.0 мянган төгрөгөөр зэрэг нийт орлого, зарлагыг 2,086,039.3 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Сумын ИТХ-ын 2023 оны 12 дугаар сарын 19-ний өдрийн 81 дүгээр тогтоолоор:

- Орон нутгийн төсвийн орлогыг 457,929.3 мянган төгрөгөөр,

- Аймгийн төсвөөс олгох санхүүгийн дэмжлэгийг 912,420.7 мянган төгрөгөөр,
- Төсөвт байгууллагын үндсэн үйл ажиллагааны орлогыг 500.0 мянган төгрөгөөр,
- Аймгийн ОНХС-аас олгох шилжүүлгийг 323,492.3 мянган төгрөгөөр,
- Урьд оны үлдэгдлээс 157,555.5 мянган төгрөгийг,
- ОНХС-ийн урьд оны үлдэгдлээс санхүүжих 38,559.1 мянган төгрөг,
- ХХС-ийн зээлийн эргэн төлөлтөөс 208,831.0 мянган төгрөг, ХХС-ийн эхний үлдэгдлээс 46,761.0 мянган төгрөг зэрэг сумын төсвийн санхүүжүүлэх эх үүсвэрийг 2,233,683.4 мянган төгрөгөөр баталсан байна.

Аймгийн ИТХ-ын 2024 оны 09 дүгээр сарын 23-ны өдрийн 180 дугаар тогтоолоор аймгийн 2024 оны төсвийг тодотгосонтой холбоотойгоор сумын ИТХ-ын 2024 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн 108 дугаар тогтоолоор:

- ✓ Орон нутгийн төсвийн орлогыг 729,294.7 мянган төгрөгөөр,
- ✓ Аймгийн төсвөөс олгох санхүүгийн дэмжлэгийг 852,663.5 мянган төгрөгөөр,
- ✓ Аймгийн ОНХС-аас олгох шилжүүлгийг 336,875.7 мянган төгрөгөөр,
- ✓ Төсөвт байгууллагын үндсэн үйл ажиллагааны орлогыг 500.0 мянган төгрөгөөр,
- ✓ Урьд оны үлдэгдлээс 37,965.5 мянган төгрөгийг,
- ✓ ОНХС-ийн урьд оны үлдэгдлээс санхүүжих 38,559.1 мянган төгрөг,
- ✓ ХХС-ийн зээлийн эргэн төлөлтөөс 208,831.0 мянган төгрөг, ХХС-ийн эхний үлдэгдлээс 2,233.6 мянган төгрөг зэрэг сумын төсвийн санхүүжүүлэх эх үүсвэр болон зардлыг 2,299,057.9 мянган төгрөгөөр эцэслэн баталсан байна.

### 3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Гүйцэтгэлээр аймгийн төсвөөс олгох санхүүгийн дэмжлэгээс 852,663.5 мянган төгрөг, орон нутгийн төсвийн орлогоос 665,415.8 мянган төгрөг, аймгийн ОНХС-аас 325,085.1 мянган төгрөг, хоршоо хөгжүүлэх сангаас 44,872.5 мянган төгрөг, туслах үйл ажиллагааны орлогоос 1,860.3 мянган төгрөг зэрэг нийт 1,889,897.1 мянган төгрөгийн санхүүжилтийн эх үүсвэрийг бүрдүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл **1,649,375.4** мянган төгрөг буюу 71.7 хувьтай тайлагнагдсан нь ХХС-ийн зээл болон ТШЗ-д орон нутгийн төсвөөс олгох тогтмол зардлыг гүйцэтгэлээр санхүүжүүлсэн, харьяа байгууллагуудын төсвийн хэмнэлт зэргээс шалтгаалсан байна.

Урсгал зардлын гүйцэтгэлийг төлөвлөгөөтэй харьцуулбал цалин хөлс болон нэмэгдэл урамшууллын зардал 24,433.8 мянган төгрөгөөр, ажил олгогчоос төлөх НДШ-ийн зардал 1,531.4 мянган төгрөгөөр, байр ашиглалттай холбоотой тогтмол зардал 4,592.8 мянган төгрөгөөр, хангамж бараа материалын зардал 18,970.1 мянган төгрөгөөр, эд хогшил, урсгал засварын зардал 2,358.1 мянган төгрөгөөр, томилолтын зардал 2,588.1 мянган төгрөгөөр, бусдаар гүйцэтгүүлсэн ажил,

үйлчилгээний төлбөр, хураамж 2,835.8 мянган төгрөгөөр, бараа үйлчилгээний бусад зардал 6,550.9 мянган төгрөг, тэтгэмж, урамшуулал 913.6 мянган төгрөгөөр тус тус хэмнэгдсэн байна.

Тайлант онд сумын ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх 21 төсөл, арга хэмжээнд 597,098.3 мянган төгрөгийн санхүүжилт олгохоор батлагдсанаас гүйцэтгэлээр 14 төсөл, арга хэмжээнд 221,021.8 мянган төгрөгийн санхүүжилт олгож, хэрэгжээгүй болон хэмнэлтийн үлдэгдлийг орон нутгийн төсөвт төвлөрүүлсэн байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### **3.5.3 Нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Сумын ЗДТГ-ын нэмэлт санхүүжилтийн дансанд эхний үлдэгдэл 29,096.5 мянган төгрөг, туслах үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого 10,694.3 мянган төгрөг, аймгийн ЗДНХ-өөс докторуудад хүндэтгэл үзүүлэхэд 7,000.0 мянган төгрөг, өнгөт принтер худалдан авахад 1,099.0 мянган төгрөг, шатахуунд 222.1 мянган төгрөг, Статистикийн хэлтсээс хагас жилийн мал тооллогын 1,043.9 мянган төгрөг зэрэг нийт 44,155.8 мянган төгрөгийн эх үүсвэр төвлөрсөн байна.

Үүнээс цалин хөлсөнд 2,413.8 мянган төгрөг, ажил олгогчоос төлөх нийгмийн даатгалын шимтгэлийн зардалд 170.3 мянган төгрөг, байр ашиглалттай холбоотой тогтмол зардал 2,253.8 мянган төгрөг, хангамж бараа материалын зардалд 1,155.9 мянган төгрөг, багаж, техник хэрэгслийн зардалд 1,140.0 мянган төгрөг, бараа үйлчилгээний бусад зардалд 26,345.9 мянган төгрөг, 1 удаагийн тэтгэмж, урамшуулалд 7,000.0 мянган төгрөг зэрэг нийт 40,479.8 мянган төгрөгийг зориулалтын дагуу зарцуулж, үлдэгдэл 3,675.9 мянган төгрөгийг орон нутгийн төсөвт татан төвлөрүүлсэн байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

### **3.5.4 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл**

Тайлант онд аймаг, сумын ОНХС-ийн хөрөнгийн эх үүсвэрээр хэрэгжүүлэхээр төлөвлөсөн харьцуулалт болон нээлттэй тендер шалгаруулалтын аргаар гүйцэтгэх 23 төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааны урилгыг ТБОНӨХБАҮХАТ хуульд заасны дагуу tender.gov.mn цахим сайтад бүрэн байршуулж, зохион байгуулсан байна. Үүнд:

/Мянган төгрөгөөр/

Хөрөнгө оруулалтын ажлын эх үүсвэр	Төлөвлөсөн төсөл, арга хэмжээ		Харьцуулалтын арга		НТШ	
	Тоо	дүн	тоо	дүн	тоо	дүн
Сумын ОНХС	21	597,098.3	4	146,700.0	1	245,400.0
Аймгийн Замын сан	1	60,000.0	1	60,000.0		
Аймгийн ОНХС	1	400,000.0			1	400,000.0
<b>Нийт дүн</b>	<b>23</b>	<b>1,057,098.3</b>	<b>5</b>	<b>206,700.0</b>	<b>2</b>	<b>645,400.0</b>

## 4. АУДИТЫН ТАЙЛАН

### 4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Сэлэнгэ аймгийн Сант сумын төсвийн төвлөрүүлэн захирагч /цаашид Сант сумын ТТЗ гэх/-ийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдэд автомашины урсгал засвар, үр дүнгийн мөнгөн урамшуулал, үндсэн хөрөнгийн ашиглалттай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Ц.Отгонбаяр гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Б.Батмөнх, дарга, тэргүүлэх аудитор Ч.Энхтуяа нар тус тус хэрэгжүүлсэн.

Сант сумын ТТЗ-ийн 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газарт 2025 оны 02 дугаар сарын 28-ны өдрийн 01/43 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

### 4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2022 оны санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл “дунд” гэж үзлээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлангийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 1,228,122.5 мянган төгрөгөөс 1.0 хувиар буюу **12,281.2** мянган төгрөгөөр урьдчилан тогтоосныг аудитын явцад дахин хянаж, шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

### 4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилттэй холбоотойгоор дараах зардлуудыг хэмнэж ажилласан байна. Үүнд:

- ✓ Байр ашиглалттай холбоотой тогтмол зардлыг 4,592.8 мянган төгрөгөөр,
- ✓ Хангамж, бараа материалын зардлыг 18,970.1 мянган төгрөгөөр,
- ✓ Бичиг хэргийн зардлыг 1,385.2 мянган төгрөгөөр,
- ✓ Эд хогшил, урсгал засварын зардлыг 2,385.1 мянган төгрөгөөр,
- ✓ Албан томилолтын зардлыг 2,588.1 мянган төгрөгөөр,
- ✓ Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамжийг 2,835.8 мянган төгрөгөөр,
- ✓ Бараа, үйлчилгээний бусад зардлыг 6,550.9 мянган төгрөгөөр гэх мэт.

Санхүүгийн тайлангийн аудитаар Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтэд хамаарах 46 шалгуур үзүүлэлтийн дагуу горим, сорилыг гүйцэтгэж, холбогдох баримтыг тулган баталгаажуулахад **8,379.6** мянган төгрөгийн дараах зөрчлүүд илэрлээ. Үүнд:

- ✓ ЗДНХ-өөс сумын түүх соёлын дурсгалт газар, байгалийн цогцолбор газруудыг видео бичлэг, зураг, хар дүрс, фото зурагт буулган хадгалан үлдэх зорилгоор **4,879.6** мянган төгрөгийг “Монголын баялаг өв соёл” ХХК-тай гэрээ байгуулан шилжүүлж, гэрээт ажлыг хүлээн аваагүй,
- ✓ Засаг даргын нөөц хөрөнгөөс сумын эрдэмтэн, докторуудад хүндэтгэл үзүүлж, 7 докторт **3,500.0** мянган төгрөгийн гарын бэлэг өгсөн гэх мэт.

Эдгээр нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1-дэх “Төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдэд дараах зүйлсийг хориглоно”, 15.1.4: “...аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг даргын шийдвэр, тэдгээрийн хэрэгжилт, цаг үеийн шинжтэй мэдээ, мэдээллийг олон нийтэд хүргэх, сурталчлан таниулахаас бусад зорилгоор байгууллага, хамт олныг сурталчлах, салбарын болон байгууллагын үйл ажиллагаатай холбоотой нэвтрүүлэг, контент, баримтат болон цуврал киноны уран бүтээл зэргийг санхүүжүүлэх”, 15.1.5: “Төсвийн болон байгууллагын хөрөнгөөр бэлэг дурсгалын зүйл худалдан авах” гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Төрийн хэмнэлтийн тухай хуулийг хэрэгжүүлэн ажиллах албан шаардлага хүргүүлэх.

### 4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

#### 4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд сумын ТТЗ болон харьяа байгууллагуудын шилэн дансны мэдээлэл байршуулалтыг хүснэгтээр харуулбал дараах байдалтай байна. Үүнд:

Хүснэгт 10. ТТЗ болон харьяа байгууллагуудын шилэн дансны мэдээлэл байршуулалт

Д/д	Байгууллагын нэр	Мэдээлбэл зохих	Мэдээлсэн	Хугацаа хоцроосон	Огт мэдээлээгүй
1	Засаг даргын тамгын газар	171	169	2	
2	Иргэдийн Төлөөлөгчдийн хурал	171	169	2	
3	ТТЗ	145	141	4	
	<b>Нийт дүн</b>	<b>487</b>	<b>479</b>	<b>8</b>	

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай бүрэн нийцээгүй байна гэж дүгнэлээ.

#### 4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

1. Сумын ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэхээр баталсан 1 төсөл арга хэмжээний гүйцэтгэгчид урьдчилгаа төлбөрийн баталгаа гаргуулалгүйгээр 70.0 хувийн урьдчилгаа санхүүжилтэд нийт **14,000.0** мянган төгрөг олгосон байна. Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 43 дугаар зүйлийн 43.3 дахь “*Урьдчилгаа төлбөрийн баталгаа гаргаагүй бол захиалагч урьдчилгаа төлбөр төлөхийг хориглоно*” гэсэн заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Урьдчилгаа төлбөрийн баталгаагүйгээр урьдчилгаа олгосон зөрчлийг давтан гаргахгүй ажиллах албан шаардлага хүргүүлэв.

#### 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

##### 4.5.1 Завсрын аудитын талаар

Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудиторын 2024 оны 10 дугаар сарын 26-ны өдрийн 122 дугаар “Санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийх тухай” албан бичгийг хүргүүлсэн бөгөөд завсрын үеийн санхүүгийн тайлангийн аудитаар алдаа, зөрчил илрээгүй байна.

##### 4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар 13,428.0 мянган төгрөгийн 5 албан шаардлага хүргүүлэн, 1 зөрчилд зөвлөмж өгөгдсөнөөс биелэлтийг аудитаар дахин хянахад 100.0 хувийн хэрэгжилттэй байна.

Хүснэгт 11. Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Төлбөрийн акт					
Албан шаардлага	5	13,428	5	13,428	100.0
Зөвлөмж	1	0	1	0	100.0
<b>Нийт дүн</b>	<b>6</b>	<b>13,428</b>	<b>6</b>	<b>13,428</b>	<b>100.0</b>

#### 4.5 Дараагийн аудитаар анхаарах асуудал

1.Цаг хугацаа, хүн хүчний хязгаарлагдмал байдлын улмаас ОНХО, ОНХС-ийн эх үүсвэрээр гүйцэтгэгдэж буй хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний санхүүжилт, бүртгэл тайлагналтай холбоотой асуудлуудыг тулган баталгаажуулсан боловч төлөвлөлт, гүйцэтгэл, худалдан авах ажиллагаатай холбоотой асуудлуудыг санхүүгийн тайлангийн аудитад бүрэн хамруулах боломжгүй байлаа. Иймээс “Улс, орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын үр дүн”, “ОНХС-ийн 2024 оны хэрэгжилт, үр дүн” сэдэвт гүйцэтгэлийн аудитаар гүнзгийрүүлэн шалгах шаардлагатай юм.

2.Сэлэнгэ аймгийн Сант сумын **төсвийн төвлөрүүлэн захирагчийн бус дээд шатны төсвийн захирагчийн шийдвэрээр** хэрэгжсэн дараах асуудлыг дээд шатны төсвийн захирагчийн санхүүгийн тайланд хийх аудитын анхааралд хандуулж байна. Үүнд:

- Аймгийн төсвийн Ерөнхийлөн захирагчаас малын хөлийн татварын 98,717.8 мянган төгрөгийг суурь орлогод тооцож баталсан, ҮХХАТ-ын сүүлийн 3 жилийн дундаж гүйцэтгэл 2,000.0 мянган төгрөг байхад аймгийн төсвийн орлогын мэргэжилтэн орон андуурч 20,000.0 төгрөгөөр тооцсон зэргээс шалтгаалж, аймгаас олгох санхүүгийн дэмжлэгийг багасгаж, төсвийн зардлыг санхүүжүүлэхийн тулд сумын төсвийн орлогыг хий нэмэгдүүлэн төлөвлөж, төлөвлөгөөг **110,024.1** мянган төгрөгөөр буюу 15.1 хувиар тасалсан байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.2 дахь “*төсвийн иж бүрэн, үнэн зөв байдлыг хангасан байх*”, 41 дүгээр зүйлийн 41.2.1 дэх “*Хуулийн дагуу улс, орон нутгийн төсөвт оруулах болон тухайн төсвийн байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлогыг бүрэн төвлөрүүлэх*” гэсэн заалтуудыг зөрчсөн байна.

## 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитын явцад нягтлан бодох бүртгэлтэй холбоотой нийт 134.476.5 мянган төгрөгийн залруулаагүй алдаанд<sup>1</sup> зөвлөмж өглөө. Үүнд:

### Залруулаагүй алдаа:

- ЗДТГ нь данс хооронд шилжүүлсэн 36 нэр төрлийн 134.476.5 мянган төгрөгийн балансын үнэтэй үндсэн хөрөнгийн ашиглалтын хугацааг тогтоогоогүй байгаа нь цаашид элэгдлийн зардал тооцогдохгүй байх эрсдэлийг үүсгэж байна.

Өгсөн зөвлөмж: Данс хооронд шилжүүлсэн үндсэн хөрөнгийн ашиглалтын хугацааг тогтоож, 2025 оны эхний хагас жилийн санхүүгийн тайланд залруулах.

Аудитаар нийт **21,908.9** мянган төгрөгийн зөрчил<sup>2</sup> илэрснээс **16,280.2** мянган төгрөгийн албан шаардлага хүргүүлэн **5,628.7** мянган төгрөгийн зөвлөмж өглөө.

### 5.1 Албан шаардлага:

**5.1.1** ЗДНХ-ийн батлагдсан төсвөөс дараах 10.549.7 мянган төгрөгийг зориулалт бусаар зарцуулсан байна. Үүнд:

- Сайхан сумын ШШГ-ын сургалтын танхимын засварт 8,017.0 мянган төгрөг,
- Нохой устгалын зардалд 1.532.7 мянган төгрөг,
- Баруунбүрэн сумын 100 жилийн ойд хүндэтгэл үзүүлэхэд 500.0 мянган төгрөг,
- Сайхан сумын Цагдаагийн хэлтсийн шинэ байрны нээлтэд хүндэтгэл үзүүлэхэд 500.0 мянган төгрөг.

Эдгээр нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь “*Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах*”, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалаар баталсан “Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам”-ын 2 дугаар зүйл “*Нөөц хөрөнгийн зориулалт*”-ын 2.1.1-2.1.6 дугаар заалтууд болон 2.1.5: “*Энэ журмын 2.1.1, 2.1.2-т зааснаас бусад Засаг дарга хуулиар олгогдсон бүрэн эрхээ хэрэгжүүлэхтэй холбоотой урьдчилан төлөвлөж төсөвт тусгах боломжгүй байсан нэг удаагийн шинжтэй арга хэмжээ*”, 1.2 дахь “*... урьдчилан төлөвлөж төсөвт тусгах боломжгүй байсан гэдгийг жил бүр давтагддаггүй онцгой арга хэмжээ, тохиолдлыг ... гэж ойлгоно.*” гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: ЗДНХ-ийн батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах албан шаардлага хүргүүлэв.

**5.1.2** Сумын ЗДТГ нь цэвэр усны шугам ашигласны өөрийн орлогын төлөвлөгөөр **3,139.7** мянган төгрөгөөр тасалсан байна.

<sup>1</sup> Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

<sup>2</sup> Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.1 дэх “Хуулийн дагуу улс, орон нутгийн төсөвт оруулах болон тухайн төсвийн байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлогыг бүрэн төвлөрүүлэх” гэсэн заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Төсвийн орлогыг тооцоо судалгаан дээр үндэслэн бодитоор төлөвлөж, төлөвлөсөн орлогыг бүрэн төвлөрүүлж байх албан шаардлага хүргүүлэв.

**5.1.3** Холбогдох хуулийн дагуу зайлшгүй гарах байгууллагаас төлөх ЭМД-ын шимтгэлийн зардлыг төсөвт тусгаж төлөвлөөгүйгээс цалингийн зардлын батлагдсан төсвөөс 2,140.8 мянган төгрөгийг зарцуулж, гүйцэтгэлийг бодитоор тайлагнаагүй байна. Үүнд:

**ЗДТГ:** 1,460.1 мянган төгрөг.

**ИТХ:** 680.7 мянган төгрөг.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх “... төсвийг төлөвлөх, батлах, хэрэгжүүлэх, тайлагнахад дараах зарчмыг баримтална: 5.1.2 дахь “ 5.1.2.төсвийн иж бүрэн, үнэн зөв байдлыг хангасан байх;” Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 дэх “Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн зөв гаргах үндэслэл болно” гэсэн заалтууд болон Сангийн сайдын 2021 оны 190 дүгээр тушаалаар баталсан “Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар”-ыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Төсвийг иж бүрэн, үнэн зөв төлөвлөж байх албан шаардлага хүргүүлэв.

**5.1.4** Сумын ЗДТГ нь санхүүгийн программын **450.0** мянган төгрөгийн өр төлбөрийг өмнөх оны санхүүгийн тайланд тусгалгүйгээр тайлант оны батлагдсан төсвөөс барагдуулж, зардлаар тайлагнасан байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1 дэх “Төсвийн жил нь тухай оны 1 дүгээр сарын 01-ний өдөр эхэлж, тухайн оны 12 дугаар сарын 31-ний өдөр дуусгавар болно.”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4 дэх “Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ:”, 14.4.3: бүх өр төлбөр” гэсэн заалтыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Өр төлбөр үүсгэхгүй ажиллах, үүссэн тохиолдолд санхүүгийн тайланд тусгасны үндсэн дээр барагдуулж байх албан шаардлага хүргүүлэв.

## **5.2 Зөвлөмж**

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

### **1.Зардлын данстай холбоотой асуудал**

Илрүүлэлт: ЗДТГ нь Өмч хамгаалах зөвлөлөөр эвдрэл, гэмтлийг тогтоогоогүй буюу техникийн комиссын акт, дүгнэлтгүйгээр автомашины засвар үйлчилгээнд 1,557.0

мянган төгрөгийг зарцуулсан нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 дэх "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн зөв гаргах үндэслэл болно", 13.7 дахь "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно" гэсэн заалтуудыг зөрчсөн байна.

Өгсөн зөвлөмж: Техникийн комиссын дүгнэлтийг үндэслэн автомашины засварын зардлыг гаргаж байх.

## **2. Үр дүнгийн мөнгөн урамшуулалтай холбоотой асуудал**

Илрүүлэлт: ЗДТГ нь төрийн албан хаагчдын ажлын үр дүнг улирал бүр үнэлж, үр дүнгийн урамшуулал олгожгүйгээр хагас, бүтэн жилээр дүгнэн, урамшууллыг дутуу олгосон байна. Энэ нь Засгийн газрын 2019 оны 5 дугаар тогтоолын 3 дугаар хавсралтаар батлагдсан ЗТөрийн албан хаагчид мөнгөн урамшуулал олгох журам"-ын 1.2-д "Төрийн албан хаагчийн ажлын гүйцэтгэлийн үнэлгээ, улирлын ажлын үр дүнг үндэслэн төрийн албан хаагчид дараах эрх бүхий албан тушаалтан мөнгөн урамшуулал олгоно" гэсэн заалтыг зөрчсөн байна.

Өгсөн зөвлөмж: Албан хаагчийн ажлын гүйцэтгэлийн үнэлгээ, улирлын ажлын үр дүнг үнэлэн улирал бүр үр дүнгийн мөнгөн урамшуулал олгож байх.

## **3. Үндсэн хөрөнгийн ашиглалттай холбоотой асуудал**

Илрүүлэлт: ЗДТГ нь элэгдлээрээ анхны өртгөө бүрэн нөхсөн, цаашид ашиглах боломжгүй 4,071.7 мянган төгрөгийн балансын үнэтэй 3 мотоциклийг холбогдох байгууллагад уламжилж данс бүртгэлээс хасуулах арга хэмжээ авч ажиллаагүй байна. Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.2-т "илүүдэл эд хөрөнгө болон элэгдэл хорогдлын шимтгэлээр анхны үнийг нь нөхсөн, түүнчлэн нөхөөгүй боловч гэмтэж, засаж сэлбээд өөр зориулалтаар ашиглаж болох эд хөрөнгийн үнийг төрийн өмчийн бодлого, зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагатай зөвшилцөн тогтоох" гэсэн заалтыг зөрчсөн байна.

Өгсөн зөвлөмж: Элэгдлээрээ анхны өртгөө бүрэн нөхсөн, цаашид ашиглах боломжгүй үндсэн хөрөнгүүдийг холбогдох байгууллагад уламжилж, данс бүртгэлээс хасах.

Дээрх зөвлөмжүүдийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг Төрийн аудитын тухай хуулийн 20.5<sup>3</sup> дахь заалтад тусгасны дагуу аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор, биелэлтийг 2025 оны 06 дугаар сарын 25-ны өдрийн дотор тус тус төрийн аудитын байгууллагад ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

---

<sup>3</sup> Шалгагдагч этгээд болон холбогдох бусад албан тушаалтан нь энэ хуулийн 20.2-т заасан зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор төрийн аудитын байгууллагад ирүүлнэ.

**6. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл**

**Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл**

Байгууллагын нэр	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
							Тоо	Дүн	Тоо	Дүн		
ЗДТГ	1	134,476.5	1	134,476.5					1	134,476.5	1	134,476.5
<b>Дүн</b>	<b>1</b>	<b>134,476.5</b>	<b>1</b>	<b>134,476.5</b>					<b>1</b>	<b>134,476.5</b>	<b>1</b>	<b>134,476.5</b>

/мянган төгрөгөөр/

**Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл**

/мянган төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт зөрчил						Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
ТТЗ	1	10,549.7			1	10,549.7										
ИТХ	1	680.7			1	680.7										
ЗДТГ	6	10,678.5			3	5,049.8			3	5,628.7						
<b>Дүн</b>	<b>8</b>	<b>21,908.9</b>			<b>5</b>	<b>16,280.2</b>			<b>3</b>	<b>5,628.7</b>						

Үүнээс

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

Байгууллагын нэр	/мянган төгрөгөөр/									
	Нийт зөрчил		Төлбөрийн акт		Үүнээс		Зөвлөмж			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил										
<b>Дүн</b>										
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил										
<b>ТБОНӨХБАУХАТ хуулийн хэрэгжилттэй холбоотой</b>										
Урьдчилгаа төлбөрийн баталгаагүйгээр урьдчилгаа санхүүжилт олгосон.	1	14,000.0					1	14,000.0		
<b>Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой</b>										
Цаг үеийн шинжтэй мэдээ, мэдээллийг олон нийтэд хүргэх, сурталчлан таниулахаас бусад зорилгоор видео контент, нэвтрүүлэг бэлтгэсэн, төсвийн хөрөнгөөр бэлэг дурсгалын зүйл худалдан авсан.	1	8,379.6					1	8,379.6		
<b>Нийт дүн</b>	<b>2</b>	<b>22,379.3</b>					<b>2</b>	<b>22,379.3</b>		